



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 19 өдөр

Дугаар A/486

Мэрэн сүм

Г Мал бүртгэх ажлыг эрчимжүүлэх
тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8, Малын генетик нөөцийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3, Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/405 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/405 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд баталгаажсан үүлдэр омгийн мал, төл малыг бүртгэх ажлыг зохион байгуулсугай.
2. Малыг ээмэглэх, бүртгэлжүүлэх ажлын зардлыг жил бүр орон нутгийн төсөвт суулгахыг сумдын Засаг дарга наарт үүрэг болгосугай.
3. Баталгаажсан үүлдэр, омгийн мал, жил бүрийн төлийг технологит хугацаанд нь мал бүртгэлийн журмын дагуу ээмэглэх, бүртгэлжүүлэх ажлыг чанартай зохион байгуулахыг сумын Засаг даргын Тамгын газарт даалгасугай.
4. Мал ээмэглэх, бүртгэлжүүлэх ажлыг стандартын дагуу зохион байгуулахад мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр)-т үүрэг болгосугай.
5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ